



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Ж - СУ - 2 - 01 -03

**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ
СУРГАЛТ ЭРХЛЭХ ЖУРАМ**

ЭХ ХУВЬ 1

2022

Боловсруулсан:	Хянан засварласан	Хянасан:	Баталсан:
ЭШМТА-ны Сургалт, төслийн ажилтан	ЭШМТА-ны дарга	ЦЧАБА-ны дарга	ЦССҮТ-ийн Ерөнхий захирал
Э.Энхболор	Б.Солонго	А.Амарзаяа	Н.Эрдэнэбаяр
Огноо: 2022.09-15	Огноо: 2022.10.11	Огноо: 2022.11.21	Огноо: 2022.11.21
Гарын үсэг	Гарын үсэг	Гарын үсэг	Гарын үсэг



Өөрчлөлт хийгдээгүй	Албан тушаал	Гарын үсэг
Зөвшөөрсөн	ЦЧАБА-ны дарга	
Хянасан	ЭШМТА-ны дарга	
Хүчинтэй хугацаа	2026 он 11 сар 21 өдөр	

Агуулга

Д/д	Бүлэг	Хуудас
-----	-------	--------

- | | | |
|----|----------------------------------|------|
| 1. | Өөрчлөлт оруулсан бүртгэл | 1 |
| 2. | Тодорхойлолт, товчилсон үг | 5 |
| 3. | Зорилго | 5 |
| 4. | Хамрах хүрээ | 5 |
| 5. | Үүрэг хариуцлага | 5-7 |
| 6. | Журмаар зохицуулах үйл ажиллагаа | 8-13 |
| 7. | Лавлах, эш татсан материал | 13 |
| 8. | Хавсралт | 13 |
| 9. | Холбогдох баримт бичиг | 13 |

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.14	Хуудас 3 / 23

1. ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮРТГЭЛ

Д.д	Хуудас №	Бүлэг №	Өөрчлөлт оруулсан огноо	Оруулсан өөрчлөлтийн утга	Шалтгаан	ЧАД-н гарын үсэг
1	1-12	1-5	2018.06.25	Шинэчилсэн журмын холбогдох заалтад нийцүүлэв.	ЭМС-ын 2017 оны А/337 дугаар тушаалыг 2048 оны 1 сараас мөрдсөнтэй холбоотой өөрчлөв.	
2	13-15		2020.06.26	Бүртгэл, шалгах хуудас нэмэв.		
3	13, 14, 16		2022.10.11	Шалгах хуудас хассан, шалгалтын өмнөх зар хүргэх, богино хугацааны сургалтын бүртгэлийг хасч шинэчлэн.	Баримт бичиг шинэчлэхтэй холбоотой.	

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба					
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03			Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо:	Хуудас 4 / 23	

1.Тодорхойлолт, товчилсон үг:

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг зохицуулна.

ЦССҮТ- Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв
ЭМС - Эрүүл мэндийн сайд
ЭМХТ- Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭШМТА - Эрдэм мэдээллийн технологийн алба
ЧЦАБА - Чанар, чанар аюулгүй байдлын алба

2. Зорилго

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх үйл ажиллагаатай холбоотой үүсэх харилцааг Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэнд, Боловсрол, Сангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан бодлого, чиглэл, тушаал, шийдвэр, журам болон бусад холбогдох эрх зүйн актын хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн /цаашид “Төв” гэх/ хэмжээнд зохицуулахад энэхүү журмыг ашиглана.

3. Хамрах хүрээ

ЦССҮТ-дээр төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшил болон мэргэжил дээшлүүлэх, богино хугацааны сургалтад хамрагдаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдэд хамаарна.

4. Үүрэг хариуцлага

1.Төвийн эрх

- 1.1 Суралцагчаас Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт эрхлэх журам, төвийн ажилчдын Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөхийг шаардах
- 1.2 Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулах
- 1.3 Суралцагчийн ирцийг бүртгэх, суралцах явцад хяналт тавих
- 1.4 Сургалтын төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөхийг шаардах
- 1.5 Гэрээний 3.1.4 дэх заалтад заасан нөхцөл үүсэхэд суралцагч улиран суралцаагүй, түүнчлэн тогтоосон хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд сургалтаас хасах, суралцсан хугацааны төлбөрийг буцаахгүй байх

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 5 / 23

1.6 Суралцагч нь сургалтын журам зөрчсөн, амжилтгүй суралцсан тохиолдолд зохих шийдвэрийн дагуу сургалтаас хасах

2. Төвийн үүрэг

1. Төгсөлтийн дараах сургалтын журамд заасан нийтлэг шаардлагыг биелүүлэх
2. Суралцагчийг хүлээн авч бүртгэн, сургалтын журам, төвийн сургалт эрхлэх журмыг танилцуулах
3. Сурцагчийг суралцах тойролтын хуваарьт оруулж, удирдагч багшийг томилох
4. Сургалтын удирдамж (хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, тасаг нэгжид ажиллах, шалгалт шүүлэг, реферат, лекцийн хуваарь, гардан хийх ажилбарын төрөл, тоо зэргийг тодорхой заасан)- ийг танилцуулах
5. Суралцагчаас сургалттай холбоотой аливаа хүсэлтийг хүлээн авч, албан ёсоор хариу өгөх
6. Сургалтыг тасалдуулахгүй зохион байгуулах
7. Суралцагчийг төвийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой бүхий л үйл ажиллагаанд оролцуулах
8. Нийтийг хамарсан гамшгийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал болон гамшгийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр суралцагчийг дайчлан ажиллуулах
9. Суралцагчдад суралцах орчин нөхцлөөр хангана.

3. Удирдагч багшийн үүрэг

1. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын журамд заасан нийтлэг шалгуурыг хангасан, сургалтын хөтөлбөрийн агуулгыг заах чадавхи бүхий удирдагч багш сургалтын явцыг удирдан үр дүнтэй явуулах
2. Удирдагч багш нь хөтөлбөрийн дагуу суралцсдад мэдлэг, чадвар, дадал, хандлагыг эзэмшүүлэх
3. Хөтөлбөрийн дагуу суралцагчдын мэдлэгийг шалгах сорилыг сургалтын агуулгатай нийцүүлэн байнга шинэчилж байх
4. Суралцах хугацаанд суралцагчдаас явцын шүүлэг, шалгалтыг авах
5. Дадлагын хугацаанд дагалдуулан суралцагчдаа байнга хяналт тавьж, тэдний суралцах бүхий л үйл ажиллагааг удирдан зохицуулах бөгөөд тасгуудад ажиллах үед нь хариуцан ажиллах эмч нартай нь холбож өгөх
6. Мэдлэг мэргэжлийн болон сахилгын хангалтгүй үнэлгээтэй суралцагчдыг тухай бүрт нь шаардан сануулж, шаардлагатай бол төвийн захиргаанд суралцуулахаас татгалзах хүртэл санал тавих эрхтэй.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 6 / 23

7. Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны албаны сургалттай холбоотой өгсөн үүрэг даалгавар, үнэлэлт дүгнэлтийг хүлээн авч хэрэгжүүлэх

4. Суралцагчийн эрх

1. Батлагдсан хөтөлбөрийн дагуу суралцах
2. Суралцах үйл ажилагааг дэмжсэн орчин, нөхцлөөр хангагдах
3. Суралцах үйл явцад тулгарч буй бэрхшээл, сургалтын чанартай холбоотой асуудлаар сургалт эрхлэгчид хандан хүсэлт, шаардлага тавих. Шаардлагатай тохиолдолд сургалтын талаар ЭМХТ-ийн Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн хэлтэст хандах
4. Хүндэтгэх шалтгааны улмаас сургалтыг тогтоосон хугацаанд дуусгах боломжгүй болсон тохиолдолд хүсэлтээ албан ёсоор гаргаж сургалтын албанд мэдэгдэх
5. Суралцагч нь багц цагийн шаардлагыг 100 % ханган төгсөлтийн шалгалтанд орох

5. Суралцагчийн үүрэг

1. Суралцагчид Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам, 3.3.7 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт эрхлэх журам, төвийн ажилчдын 3.3.8 Хөдөлмөрийн дотоод журмыг чанд сахих
2. Сургалтын удирдамжийг биелүүлж, идэвхи чармайлт гарган суралцах
3. Сургалтын талаар заавар зөвлөгөө авах
4. Сургалттай холбоотой төвийн бүхий л үйл ажиллагаанд оролцох
5. Нийтийг хамарсан гамшгийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал болон гамшгийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр дайчлагдан ажиллах
6. Суралцагч удирдагч багштай байнгын нягт уялдаа холбоотой байж, өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлэх
7. Суралцагч нь сургалтын хөтөлбөрийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлж, төлөвлөгөөнд заагдсан багц цагийг бүрэн гүйцээж, шалгалтыг цаг хугацаанд нь өгөх
8. Суралцагч нь суралцах хугацаанд сургалтын материалыл, хичээлийн танхим, номын санг зохих журмын дагуу ариг гамтай ашиглах

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 7 / 23

9. Сургалтаас хоцрохгүй таслахгүй, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг, мэргэжлийн үйл ажиллагааны алдаа дутагдал гаргахгүй суралцах
10. Суралцагч нь сургалтын цагт багшийн хяналтан дор гардан хийх үйлдлийг биечлэн сурч, төв дээр зохиогдох сургалт болон бусад үйл ажиллагаанд бүрэн хамрагдах
11. Анхан шатны баримт бичгийг удирдагч багш, тасгийн эрхлэгчийн хяналтан дор хөтлөх бөгөөд цусны албаны үйл ажиллагааны аливаа асуудлын талаар үзлэгийн эмч, лабораторийн эмч болон технологич эмчийн хэмжээнд шийдвэр гаргахгүй.

6. Журмаар зохицуулах үйл ажиллагаа

6.1 Сургалтын хэлбэр төрөл

- 6.1.1 Төгсөлтийн дараах сургалт нь дараах төрөлтэй байна. Үүнд:
- 6.1.2 Төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх сургалт
- 6.1.3 Мэргэжил дээшлүүлэх буюу давтан сургалт
- 6.1.4 Богино хугацааны сургалт
- 6.1.5 Төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх сургалт нь сард 4 багц цагаас доошгүй агуулгын багтаамжтай, тухайн мэргэжлийн онцлогоос хамаарч 6 сараас доошгүй хугацаатай үргэлжлэх хугацаатай байна.
- 6.1.6 Мэргэжил дээшлүүлэх сургалт нь сард 4 багц цагаас доошгүй агуулгын багтаамжтай, тухайн мэргэжлийн онцлогоос хамаарч 3 сараас доошгүй хугацаатай байна.
- 6.1.7 Мэргэшил эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг нь мэргэжлийн үнэмлэх байна.
- 6.1.8 Мэргэшил эзэмшүүлэх сургалтаар олгох мэргэжлийн жагсаалт, үргэлжлэх доод хугацааг мэргэжил тус бүрээр ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, мэргэжлийн зэрэг олгох асуудал хариуцсан орон тооны бус зөвлөлөөр (цаашид зөвлөл гэх) батлуулна.
- 6.1.9 Төгсөлтийн дараах богино хугацааны сургалт нь эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд бүрдүүлэх ёстой багц цагийг биелүүлэхэд чиглэсэн 1 сар хүртлэх хугацаатай сургалт байх ба сургалтанд хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг нь багц цагийн тэмдэглэгээ бүхий гэрчилгээ байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 8 / 23

6.2 Сургалтын удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээ

- 6.2.1 ЭМХТ-өөс зохион байгуулсан элсэлтийн шалгалт, шалгуурыг хангасан суралцагчийг товлосон хугцаанд сургалтанд хамруулна.
- 6.2.1 Мэргэшил эзэмшүүлэх болон давтан сургалтыг жил бүр заасан хугацаанд эхлүүлнэ.
- 6.2.2 Төв нь мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын журамд заасан нийтлэг шалгуурыг хангасан, сургалтын хөтөлбөрийн агуулгыг заах чадавхи бүхий багшлах бүрэлдэхүүнээр сургалтыг удирдуулна.
- 6.2.3 Эмнэлгийн мэргэжилтний давтан сургалтанд суралцах суралцагчдын нэрс болон удирдагч багш нарыг төвийн захирлын тушаалаар батална.
- 6.2.4 Төв нь багшлах бүрэлдэхүүн, суралцагчтай гурвалсан гэрээ байгуулж ажиллах бөгөөд гэрээний явц, үр дүнг тооцон дүгнэлт гаргаж, зохих журмын дагуу цалин хөлс олгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.2.5 Төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтын нийт багц цагийн 20-25 хувийг онолын сургалт, мэргэжлийн онцлогоос хамаарч 75-80-аас доошгүй хувь нь дадлагажих сургалт байна.
- 6.2.6 Сургалтын ерөнхий зохион байгуулалтыг Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны албаны асуудал хариуцсан албан тушаалтан хариуцах ба сургалтын явцад дотоод хяналт тавин, эргэн мэдээлж, жилд нэг удаа захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

6.3 Сургалтын төлбөр, зардал

- 6.3.1 Суралцагч нь сургалтын төлбөрийг хувийн зардлаар суралцаж байгаа тохиолдолд төвийн ахлах нягтлан бодогчид тушааж төлбөрийн баримтын нэг хувийг сургалт хариуцсан мэргэжилтэнд өгнө.
- 6.3.2 Сургалтын төлбөрийг эхний нэг сар дотор бүрэн төлсөн байна.
- 6.3.3 Сургалтын гэрээний хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр дуусгаагүй тохиолдолд багц цаг тооцсон нэмэлт төлбөр төлнө. Нэмэлт төлбөрийн хэмжээг талууд улиран суралцах шаардлагатай хугацааны хичээлийн багц цагийг дүнгийн дэвтэрт баталгаажсан багц цагийн хэмжээтэй харьцуулан тогтооно.
- 6.3.4 Сургалт эхэлснээс хойш төлбөрийг буцаахгүй.
- 6.3.5 Суралцагч нь сургалтын хөтөлбөрөө бүрэн хийсэн боловч төгсөлтийн шалгалтанд амжилтгүй үнэлгээ авсан бол нэг удаа шалгалт өгөх ба дахин хангалтгүй үнэлгээ авбал сургалтаас хасч төлбөрийг буцаан олгохгүй.
- 6.3.6 Сургалтын төлбөрөөс удирдагч багшийн цалин хөлс, сургалтын материалын үнэ, тоног төхөөрөмж, өрөө ашигласан зардалд зарцуулах ба сургалтаас гадуурхи үйл ажиллагаанд зарцуулахгүй.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 9 / 23

6.3.7 Сургалтын явцад дотоод болон хөндлөнгийн хяналт, суралцагчийн сурлагын амжилт, чанараас хамааран нийт сургалтын төлбөрийн 60 хувь хүртэл хувийг сургалт удирдагч багш нарын хөдөлмөрийн хөлсийг тооцож олгоно.

6.3.8 Хичээл заасан багшийн ажлын хөлсийг эрдмийн болон мэргэжлийн зэргийг харгалзан тооцоно.

6.3.9 Төгсөгчийн гэрчилгээ, гэрын авлага, ном, энгэрийн тэмдэгний үнэ сургалтын төлбөрт ороогүй бөгөөд суралцагч өөрөө төлнө.

6.3.10 Багшийн цагийн хөлс:

Д/д	Үзүүлэлт	Бакалавр болон ахлах зэргийн эмч нар	Тэргүүлэх эмчийн ба магистрын зэрэг цолтой	Доктор ба дэд профессор	ШУ-ны доктор ба профессор	Академич
1	Лекц	1200	1600	1800	2000	2500
2	Дадлага, семинар	700	900	1000	1100	1300

6.4 Суралцагчдын нийгмийн асуудал

6.4.1 Хөдөө орон нутгаас ирж суралцагчдыг суралцах хугацаанд орон байраар хангахгүй.

6.4.2 Байгууллагын зайлшгүй шаардлага болон гамшгийн үед дайчлагдан ажилласан тохиолдолд амралт олгоно.

6.4.3 Ажил мэргэжлийн онцлогоос хамаарч, тархвар судлалын заалтаар зарим вакциныг резидент эмч нарт үнэ төлбөргүй хийж болно.

6.5 Үнэлгээ

Шалгалт, шүүлэг хичээлийн явцад дараах үнэлгээний стандартыг баримтлана. Үүнд:

№	Үсгэн дүн	Хувилсан дүн	Тоон дүн
1	A	90-100%	Сургалтын дээд амжилтыг илтгэнэ.
2	B	80-89%	Дундаж түвшингээс дээгүүр
3	C	70-79%	Дундаж түвшин
4	D	60-69%	Дундаж түвшингээс хангалтгүй
5	F	60-доош	Хангалтгүй

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 10 / 23

6.5.1 Онол, дадлага, бие даалтын хичээлээр төлөвлөгөөнд заагдсан багц цагийг заавал цуглуулах ёстой. Үүний тулд:

- a. Лекцийн ирц 90% ба түүнээс дээш
- b. Дадлага ба семинарын үед ЦССҮТ дээр ажлын 5-н өдөр, өдөрт 6 –аас доошгүй цаг суралцсан.

6.5.2 Мэргэжлийн хичээлийн нийт багц цаг нь лекц, дадлага, бие даалтын багц цагийн нийлбэртэй тэнцэх ба багц цагийн дараах журмаар гүйцэтгэнэ.

- a. Лекц ба дадлагын ирцийг хувь 90 буюу түүнээс дээш /30 оноо/
- b. Явцыг шалгалт, сургалтын тайлан хамгаалалтын хангалттай үнэлгээ авсан байна /30 оноо/
- c. Гардан ажилбараар хангалттай үнэлгээ авсан байна /30 оноо/
- d. Идэвхи /10 оноо/

6.5.3 Сургалтын явцад өгөгдсөн нөхцлүүдийг биелүүлсэн тохиолдолд багц цагийг бүрэн авна.

6.5.4 Хичээлийн төгсгөлд эмч, багш нар сурлагын дэвтэр ба тооцооны хуудсанд зохих багц цаг болон үнэлгээг бөглөнө.

6.5.5 Хүндэтгэх шалтгаанаар багц цаг чадаагүй тохиолдолд удирдагч хичээл нөхөх эсэх тухай шийдвэр гаргана.

6.6 Суралцагчийг үнэлэх ба шалгалт шүүлэг авах

6.6.1 Суралцагч нь шалшалтын өмнө сургалтын хугацаанд хийсэн ажлын тайланг бичиж удирдсан багшаар үнэлүүлсэн байна.

6.6.2 Шалгалтыг сургалтын хугацаа, агуулгаас хамаарч онол ба дадлагын аль хэлбэрээр явцын ба төгсөлтийн гэж авч болно.

6.6.3 Төгсөлтийн шалгалт нь тухайн мэргэжлийг эзэмшихэд зайлшгүй мэдлэг, чадвар эзэмшсэн түвшинг тогтоож, үнэмлэх үндэслэл болно.

6.6.4 Суралцагч өөрийгөө шалгалтанд орох боломжгүй гэж үзсэн тохиолдолд сургалтын албанд бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

6.6.5 Хүндэтгэх шалтгаанаар шалгалтанд ороогүй буюу явцын шалгалтанд D,F үнэлгээ авсан суралцагчийг дахин шалгалт өгөх хугацааг комисс шийдвэрлэнэ.

6.6.6 Төгсөлтийн шалгалтанд D үнэлгээ авсан суралцагч өөрөө хүсвэл төлбөртэйгээр дахин суралцаж шалгалт өгч болно. F үнэлгээ авсан тохиолдолд энэхүү эрхийг эдлэхгүй.

6.6.7 Хүндэтгэх бус шалтгаанаар шалгалтанд ороогүй суралцагчийг F үнэлгээ авсанд тооцоно.

6.6.8 Шалгалтыг захирлыг баталсан тухайн мэргэжлийн эмч-багш, эрдэмтдээс бүрдсэн комисс авна.

6.6.9 Шалгалтын комиссын үндсэн үүрэг нь суралцагчдын мэдлэг, чадварын түвшинг тодорхойлж, үнэлгээ өгөх, шалгалтыг дүнг үндэслэн мэргэжлийн

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 -03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 11 / 23

үнэмлэх олгох асуудлыг шийдвэрлэх, сурлагын чанарыг сайжруулах санал, зөвлөмж боловсруулахад оршино.

6.6.10 Дахин авч байгаа шийдвэрлэх шалгалтыг комисс бүрэн бүрэлдэхүүнээр авч, шалгалт авсан тухай тэмдэглэл, шалгуулагчийн хариултыг дэлэгрэнгүй тэмдэглэсэн протокол үйлдэнэ. Шалгуулагчийн гарын үсэг зурсан байна.

6.6.11 Шалгалттай холбогдож гарсан маргааныг шалгалтын комисс эцэслэн шийдвэрлэнэ.

7. Лавлах материал

1. Монгол улсын Эрүүл мэндийн тухай хууль
2. Боловсролын тухай хууль
3. Дээд боловсролын тухай хууль
4. ЭМС-ын тушаал

8. Хавсралт

9. Холбогдох баримт бичиг

ЦССҮТ-ийн дотоод журам

ЭМС-ийн сайдын тушаал, шийдвэр

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 -03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.14	Хуудас 12 / 23

M-CY-4-CYA-04-03

Хавсралт 1. Багш нарын сургалтын ажлын цагийн тооцооны хуудас

№	Суралцагчийн нэрс	Сургалтад оролцогчийн тоо	Төлбөрийн хэлбэр	Сургалтын төлбөр	Нийт төлбөр	Багшийн ажлын хөлс /45%/	Байгууллагад үлдэх зардал /35%/	Сургалтын материал /15%/	Гэрчилгээ хэвлүүлэхтэй холбоотой зардал /5%/

№	Багшийн нэр	Регистрийн дугаар	Заасан цаг			Нийт багц цаг	Гарт олгох	Банкны нэр, дансны дугаар
			Лекц	Семинар	Дадлага			

Тооцоо гаргасан:.....

Хянасан:.....

Баталсан:.....

M-CY-4-CYA-10-03

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 13 / 23

Хавсралт 2. Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтын ирц бүртгэлийн хуудас

№	Овог нэр	Огноо				
1						
2						
3						

М-СУ-4-СҮА-11-03

Хавсралт 3. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын дэвтэр

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын дэвтэр

Эцэг/эхийн

нэр.....Нэр.....

Нас..... Хүйс эрэгтэй/эмэгтэй (зурна уу)

Үндсэн

байгууллага.....

.....мэргэжлээр төгсөлтийн дараах

төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх/дээшлүүлэх(зурна уу)

Суралцах хугацаа.....

Сургалтад.....оны.....сарын.....өдөр.....элссэн.

М-СУ-4-СҮА-12-03

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 -03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 14 / 23

Хавсралт 4. Төгсөлтийн дараах сургалтын явцын үнэлгээний хуудас

№	Хичээлийн нэр	Лекцийн ирцийн үнэлгээ	Дадлага хичээлийн ирцийн үнэлгээ	Семинарын ирцийн үнэлгээ	Тестийн шалгалтын үнэлгээ	Гардан үйлдлийн шалгалт	Ёс зүй, харилцаа, хандлага	Сургалт, төслийн ажилтан
1.	Баримжаа олгох хичээл							
2.	Программ хангамж							
3.	ЦЧАБА							

М-СУ-4-СҮА-08-02

Хавсралт 5. Сургалтын дараах сэтгэл ханамжийн судалгаа

Та дараах асуумжийг бөглөж сургалтыг үнэлнэ үү. Таны оролцоонд баярлалаа.

Огноо: _____

Сургалтын нэр: _____

1-----2-----3-----4-----5
Муу Дунд Хангалттай Сайн Маш
сайн

Асуулт	Дүн				
	1	2	3	4	5
Сургалтын агуулга					
Багшийн мэдлэг					
Сургалтын зааварчилгааны чанар					
Тараах материал					
Асуулт асуух, ярилцах цаг хангалттай байсан					
Сургалтын агуулга нь ажилд хэрэгтэй байсан					

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 15 / 23

Хавсралт 6. Суралцагчтай байгуулах гэрээ

БАТЛАВ

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭБАЯР

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТ ЭРХЛЭХ
БАЙГУУЛЛАГА, СУРАЛЦАГЧ ХООРОНД БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

Улаанбаатар

№....

20.... оны сарын –ний өдөр

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү гэрээг нэг талаас сургалт эрхлэгч байгууллага болох **Цус сэлбэлт судлалын үндэсний төв** /цаашид сургалт эрхлэх байгууллага гэх/, түүнийг төлөөлж Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны Сургалт төслийн ажилтан **Энтер** овогтой **Энхболор**, нөгөө талаас **Цус, цусан бүтээгдэхүүний технологич мэргэжил дээшлүүлэх** сургалтад суралцагч овогтой РД:..... (цаашид суралцагч гэх) нар харилцан тохиролцож энэхүү

Хоёр. Гэрээний үндсэн зорилго, хугацаа

- 2.1. Энэхүү гэрээ нь сургалт явуулах хугацаанд талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад гэрээний зорилго оршино.
- 2.2. Сургалтын журамтай урьдчилан танилцаж, нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрсөн байна.
- 2.3. Тус гэрээ нь гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 2.4. Энэхүү гэрээг талууд 2022 оны 10-р сарын 01-ээс 2023 оны 01-р сарын 31-ийг хүртэлх хугацаагаар байгуулав.

Гурав. Сургалтын төлбөр

- 3.1. Суралцагч нь сургалтын төлбөр болох 192.000 төгрөгийг Төрийн сан дахь Сургалт эрхлэгч байгууллагын 100900020410 тоот дансанд шилжүүлэн төлбөрийн баримтын нэг хувийг Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албанд өгнө.
- 3.2. Сургалтын төлбөрийг сургалт эхэлснээс хойш эхний сард багтаан бүрэн төлсөн байна.
- 3.3. Сургалтыг гэрээний хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр дуусгаагүй тохиолдолд багц цаг тооцсон нэмэлт төлбөр төлнө. Нэмэлт төлбөрийн хэмжээг

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 16 / 23

талууд улиран суралцах шаардлагатай хугацаан дахь хичээлийн багц цагийг дүнгийн дэвтэрт баталгаажсан багц цагийн хэмжээтэй харьцуулан тогтооно.

3.4. Сургалтыг гэрээний хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр нэг сар хүртэлх хугацаагаар сургалтаас завсардсан тохиолдолд суралцагчтай байгуулсан гэрээнд заасан нэмэлт төлбөр авч сургалтын хөтөлбөрийг нөхүүлэх

3.5. Суралцагч хүндэтгэх шалтгаангүй нэг сар ба түүнээс дээш хугацаагаар сургалтаас завсардсан эсхүл тогтоосон хугацаанд төлбөр төлөөгүй тохиолдолд сургалтаас хасах

3.6. Сургалтын дундаас тасалдсан сургалтын төлбөрийг буцаан олгохгүй.

3.7. Суралцагч нь сургалтын хөтөлбөрөө бүрэн биелүүлсэн боловч төгсөлтийн шалгалтанд амжилтгүй үнэлгээ авсан бол нэг удаа нэмэлт шалгалт өгөх боломжтой бөгөөд дахин хангалтгүй үнэлгээ авбал сургалтаас бүр мөсөн хасна.

Дөрөв. Сургалт эрхлэгч байгууллагын хүлээх эрх, үүрэг

4.1. Сургалт эрхлэгч байгууллага нь дараах эрх эдэлнэ:

4.1.1. Суралцагчаас эмнэлгийн мэргэжилтний давтан сургалтын журам, байгууллагаас баталсан сургалт эрхлэх журам, байгууллагын дотоод журмыг мөрдөхийг шаардах;

4.1.2. Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулах;

4.1.3. Суралцагчийн ирцийг бүртгэх, суралцах явцад хяналт тавих;

4.1.4. Сургалтыг хугацаанд нь дуусаагүй, хүндэтгэх шалтгаангүйгээр сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн 20 ба түүнээс дээш хувийг гүйцээгээгүй тохиолдолд энэхүү гэрээний 3.3-т заасан төлбөрийг авах;

4.1.5. Сургалтын төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөхийг шаардах;

4.1.6. Гэрээний 4.1.4. дэхь заалтад заасан нөхцөл үүсэхэд суралцагч улиран суралцахгүй, түүнчлэн тогтоосон хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд сургалтаас хасах, суралцсан хугацааны төлбөрийг буцаахгүй байх;

4.1.7. Сургалтын журам зөрчсөн, амжилтгүй суралцсан суралцагсадыг Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны гаргасан зохих шийдвэрийн дагуу сургалтаас хасах асуудлыг шийдвэрлэнэ.

4.2. Сургалт эрхлэгч дараах үүрэг хүлээнэ:

4.2.1. Төгсөлтийн дараахь журамд заасан нийтлэг шаардлагыг биелүүлэх;

4.2.2. Суралцагчийг хүлээн авч бүртгэн, эмнэлгийн мэргэжилтний давтан сургалтын журам, байгууллагын сургалт эрхлэх журмыг танилцуулан сургалтын гэрээний 1 хувийг өгөх;

4.2.3. Суралцагчийг суралцах нэгжид хуваарилж, удирдагч багшийг томилох;

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 17 / 23

4.2.4. Сургалтын удирдамж (хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, тасаг нэгжид тойрох, үзлэг, шалгалт шүүлэг, реферат, лекцийн хуваарь, гардан хийх ажилбарын төрөл, тоо зэргийг тодорхой заасан)-г танилцуулж, хүлээлгэн өгөх;

4.2.5. Суралцагчаас сургалттай холбоотой тавьж болох аливаа хүсэлтийг хүлээн авч, албан ёсоор хариу өгөх;

4.2.6. Сургалтыг тасалдуулахгүй зохион байгуулах;

4.2.7. Суралцагчийг эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой бүхий л үйл ажиллагаанд оролцуулах;

4.2.8. Нийтийг хамарсан гамшгийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал зарлагдсан тохиолдолд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр суралцагчийг дайчлан ажиллуулах;

4.2.9. Сургалтыг амжилттай төгсөгчдөд мэргэжлийн диплом, үнэмлэх олгох;

4.2.10. Сургалт зохион байгуулагч нь төгсөгчдийг ажлын байраар хангахгүй.

4.2.11. Сургалтын хугацаанд суралцах нөхцөл бололцоогоор хангах /хичээлийн танхим, сургалтын материал, ном сурах бичиг, хэрэглэгдэхүүн, багаж тоног төхөөрөмж, интернет, клиникийн тасаг лаборатори, судалгааны материал, энгэрийн тэмдэг, сурлагын дэвтэр/.

4.2.12. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага, анагаах ухааны боловсролын байгууллага, сургалт эрхлэх байгууллага (сургалт эрхлэх байгууллагын сүлжээ)-аас шинээр болон шинэчлэн боловсруулсан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг хянаж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах

4.2.13. Улсын төсвийн болон орон нутгийн санхүүжилтээр мэргэшүүлэх сургалт төгсөгч эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих

4.2.14. Элсэгч, суралцагч, төгсөгчтэй холбоотой цахим мэдээний санг тогтмол ажиллуулах, боловсронгуй болгох, хяналт тавих

4.2.15. Сургалтын үйл явцийг үнэлэх, дотоод хяналт тавих

Тав. Суралцагчийн хүлээх эрх, үүрэг

5.1. Суралцагч дараах эрх эдэлнэ:

5.1.1. Батлагдсан хөтөлбөрийн дагуу суралцах;

5.1.2. Эмнэлгийн мэргэжилтний давтан сургалтын журмын 4.2-т заасан суралцах үйл ажиллагааг дэмжсэн орчин, нөхцлөөр хангагдах;

5.1.3. Суралцах үйл явцад тулгарч буй бэрхшээл, сургалтын чанартай холбоотой асуудлаар сургалт эрхлэгчид хандан хүсэлт, шаардлага тавих.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 -03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 18 / 23

Шаардлагатай тохиолдолд сургалтын талаар Эмнэлгийн мэргэжилтний хөгжил, давтан сургалтын зөвлөлд хандах;

5.1.4. Хүндэтгэх шалтгааны улмаас сургалтыг тогтоосон хугацаанд дуусгах боломжгүй болсон тохиолдолд хүсэлтээ журмын дагуу тавьж, чөлөө авах, хойшлуулах;

5.1.5. Удирдагч багшаа өөрчлөх хүсэлт гаргах;

5.1.6. Суралцагч нь 80-100% -ийн багц цагийн шаардлагыг ханган, төгсөлтийн шалгалтанд орох эрхтэй.

5.2. Суралцагч дараахь үүрэг хүлээнэ.

5.2.1. Сургалт эрхлэгч байгууллагын дотоод журам, сургалтын журам, суралцах үйл ажиллагаанд хамаарах бусад дүрэм журмуудыг чанд сахих;

5.2.2. Сургалтын удирдамжийг биелүүлж, идэвхи чармайлт гарган суралцах;

5.2.3. Сургалтын талаар заавар зөвлөгөө авах;

5.2.4. Сургалттай холбоотой сургалт эрхлэгч байгууллагын бүхий л үйл ажиллагаанд оролцох;

5.2.5. Нийтийг хамарсан гамшгийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал болон гамшгийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр дайчлагдан ажиллах;

5.2.6. Удирдагч багштай байнгын нягт уялдаа холбоотой байж өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлэх;

5.2.7. Суралцагч нь сургалтын хөтөлбөрийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлж, төлөвлөгөөнд заагдсан багц цагийг бүрэн гүйцээж, шалгалтыг цаг хугацаанд нь өгөх;

5.2.8. Суралцагч нь суралцах хугацаандаа сургалтын материал, хэрэглэгдэхүүн, хичээлийн танхим, номын санг зохих журмын дагуу ариг гамтай ашиглах;

5.2.9. Номын сангаас ном, сурах бичиг, мэргэжлийн сэтгүүлийг ашиглахдаа тухайн тасгийн ном хариуцсан мэргэжилтний зөвшөөрлөөр картанд бүртгүүлж, уншлагын танхимд ашиглан буцааж өгөх;

5.2.10. Хичээл хоцрохгүй таслахгүй, эмчийн ёс зүй, мэргэжлийн үйл ажиллагааны алдаа дутагдал гаргахгүй суралцах;

5.2.11. Суралцагч нь сургалтын цагт багшийн хяналтан дор донор элсүүлэх, донор зохион байгуулалтын тасаг, үйлдвэрлэлийн тасаг, нэгдсэн лабораторийн тасагт ажиллаж, гардан үйлдэлийг биечлэн хийж сурах, бааз тасаг, нэгжүүд дээр зохиогдох эмч нарын яриа зөвлөгөөнд бүрэн хамрагдах;

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 19 / 23

5.2.12. Анхан шатны бичиг баримт, тайлан гаргах маягт зэргийг удирдагч багш, тасгийн даргын хяналтан дор хөтлөх бөгөөд талаар мэргэжлийн трансфузиологч эмчийн эрх эдлэхгүй.

5.2.13. Суралцагч нь сургалтын хөтөлбөрийн дагуу тасаг бүрийн тойролтын дараа тайлан бичиж хамгаалах, явцийн шалгалт өгөх, суралцагчдын хичээлийн ирц 70%-с дээш тохиолдолд нэгдсэн шалгалтад орох эрх үүснэ.

Зургаа. Удирдагч багшийн хүлээх эрх, үүрэг

6.1. Сургалт удирдах багш нь ЭМС-ын 2017 оны А/337 дугаар тушаалын хавсралтын Аравт заасан шаардлагыг хангасан байх бөгөөд Дараах эрх, үүрэгтэй байна:

6.1.1. Дадлага, семинарын явцад анхаарал тавин түүнийг үр дүнтэй явуулах;

6.1.2. Удирдагч нь хөтөлбөрийн дагуу суралцагсдад мэдлэг, дадлага, чадвар эзэмшүүлэх;

6.1.3. Хөтөлбөрийн дагуу суралцагчийн мэдлэгийг шалгах сорилыг сургалтын агуулгатай нийцүүлэн байнга шинэчилж байх;

6.1.4. Суралцах хугацаанд суралцагчдаас зохих шүүлгийн шалгалт авах;

6.1.5. Дадлагын хугацаанд дагалдуулан суралцагчдаа байнга хяналт тавьж, тэдний суралцах бүхий үйл ажиллагааг удирдан зохицуулах бөгөөд тасгуудад ажиллах үед нь хариуцан ажиллах эмч нартай нь холбож өгөх;

6.1.6. Мэдлэг мэргэжлийн болон сахилгын хангалтгүй үнэлгээтэй суралцагчдыг тухай бүрт нь шаардан сануулж, шаардлагатай бол байгууллагын захиргаанд суралцуулахаас татгалзах хүртэл санал тавих;

6.1.7. Эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны албанаас сургалттай холбоотой өгсөн үүрэг даалгавар, үнэлэлт дүгнэлтийн хүлээн авч хэрэгжүүлэх;

6.1.8. Удирдагч багшид удирдсан цагийн хөлсийг лекц, дадлагын хөлс авах.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан маргааныг сургалтын дотоод хяналтын журам, сургалтын журмын дагуу шийдвэрлэх ба шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 20 / 23

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

СУРГАЛТ ЭРХЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫГ
ТӨЛӨӨЛЖ:

ЦССҮТ-ийн Эрдэм шинжилгээ,
мэдээллийн технологийн алба Сургалт,
төслийн ажилтан

Э.Энхболор

СУРАЛЦАГЧ:

Харъяа байгууллага:

Албан тушаал:
..... овогтой.....

/гарын үсэг/

Утас:

И-мэйл хаяг:

“Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв”

Хаяг: БЗД Улсын хоёрдугаар төв

эмнэлгийн зүүн талд

Утас: (976 - 11) – 70136504, 70112857

Факс: (976 - 11) - 70112857

Хавсралт 7. Төрөлжсөн мэргэжлийн сургалтын хичээлийн хуваарийн загвар

M-CY-4-CYA-03-03

"ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТЕХНОЛОГИЧ" СУВИЛАГЧИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХИЧЭЭЛИЙН ХУВААРЬ 2022-2023 ОН									
I долоо хоног					VIII долоо хоног				
Давсаа Х/10	Мягмар Х/11	Лхагва Х/12	Пүрэв Х/13	Баасан Х/14	Давсаа Х/25	Мягмар Х/26	Лхагва Х/27	Пүрэв Х/28	Баасан Х/29
Баримжаа олгох Лекц-1.2		Баримжаа олгох Лекц-3		Шалгалт	Лекц-1.2		Лекц-3,4,5	Дадлага	Шалгалт
II долоо хоног					IX долоо хоног				
Давсаа Х/17	Мягмар Х/18	Лхагва Х/19	Пүрэв Х/20	Баасан Х/21	Давсаа Х/03	Мягмар Х/04	Лхагва Х/05	Пүрэв Х/06	Баасан Х/07
	Лекц-1.2		Лекц-3,4	Лекц-5,6,тест	Лекц-1.2	Лекц-1.2 тест	Семинар 1.2		Дадлага 1-2
III долоо хоног					X долоо хоног				
Давсаа Х/24	Мягмар Х/25	Лхагва Х/26	Пүрэв Х/27	Баасан Х/28	Давсаа Х/11	Мягмар Х/12	Лхагва Х/13	Пүрэв Х/14	Баасан Х/15
	Лекц-1-6 тест	Семинар 1		Дадлага 1,2		Лекц-1.2	Лекц-1.2 тест	Семинар-1,2	Дадлага 1,2
IV долоо хоног					XI долоо хоног				
Давсаа Х/31	Мягмар Х/01	Лхагва Х/02	Пүрэв Х/03	Баасан Х/04	Давсаа Х/18	Мягмар Х/19	Лхагва Х/20	Пүрэв Х/21	Баасан Х/22
	Семинар 2	Дадлага 3,4	Дадлага 5,6			Лекц-3,4	Лекц-3,4 тест	Семинар-3,4	Дадлага 3-4
V долоо хоног					XII долоо хоног				
Давсаа Х/07	Мягмар Х/08	Лхагва Х/09	Пүрэв Х/10	Баасан Х/11	Давсаа Х/25	Мягмар Х/26	Лхагва Х/27	Пүрэв Х/28	Баасан Х/29
	Лекц-1,2	Лекц-1,2 тест	Семинар 1,2	Дадлага 1-2		Семинар 5,6	Дадлага 5,6	Дадлага 7,8	
VI долоо хоног					XIII долоо хоног				
Давсаа Х/14	Мягмар Х/15	Лхагва Х/16	Пүрэв Х/17	Баасан Х/18	Давсаа I/2	Мягмар I/3	Лхагва I/4	Пүрэв I/5	Баасан I/6
	Лекц-3,4	Лекц-3,4,тест	Семинар-3,4	Дадлага 3-4	УНТЭ, ЭХЭМҮТ, ГССҮТ, ХСҮТ				
VII долоо хоног					XIV долоо хоног				
Давсаа Х/21	Мягмар Х/22	Лхагва Х/23	Пүрэв Х/24	Баасан Х/25	Давсаа I/9	Мягмар I/10	Лхагва I/11	Пүрэв I/12	Баасан I/13
	Лекц-5,7	Лекц-5,7 тест	Семинар5,7	Дадлага 5,7	Тайлан хамгаалалт, шалгалт				
		Баримжаа олгох хичээл	НЛТ				Программ хангамж		
		ДЭБТ	Үйлдвэрлэлийн тасаг				ЦЧАБА		

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба

Баримт бичгийн дугаар:

Ж - СУ - 2 - 01 - 03

Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах
сургалт эрхлэх журам

Хувилбар №03

Мөрдөж эхэлсэн
огноо:2017.04.01

Өөрчлөлт 3

Өөрчлөлт оруулж,
шинэчилсэн огноо:
2022.10.11

Хуудас 21 / 23

Хавсралт 8. Сургалтын бүртгэлийн хуудас

M-CY-4-CYA-06-03

M-CY-4-CYA-06-01

Сургалтын бүртгэлийн хуудас

Байгууллагын нэр: |

Сургалтын нэр:

Огноо:

Зөвхөн багш:

№	ОВОГ,НЭР	АЛБАН ТУШААЛ	ГАРЫН ҮСЭГ
1			
2			
3			
4			

Хавсралт 9. Төгсөлтийн дараах сургалтын төгсөлтийн шалгалтын протокол

M-CY-4-CYA-13-03

ТӨГСӨЛТИЙН ДАРААХ СУРГАЛТЫН ТӨГСӨЛТИЙН ШАЛГАЛТЫН ПРОТОКОЛ

№

Огноо:

Шалгалтын явц:

Хөндлөнгийн хяналт:

Дүнгийн дэлгэрэнгүй:

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Онолын дүн /%/	Дадлага шалгалтын дүн /%/
---	------	-----	----------------------	-------------------	---------------------------------

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо:2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 22 / 23

Хавсралт 10. Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтын төгсөлтийн шалгалтын дүнгийн хуудас

M-CY-4-CYA-14-03

M-CY-4-CYA-13-03

Төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалтын төгсөлтийн шалгалтын дүнгийн хуудас

Он, сар, өдөр: _____

Д/д	Овог нэр	Тайлан хамгаалалтын дүн [%]	Гардан шалгалтын дүн [%]	Тестийн шалгалтын дүн	Нэгдсэн дүн

Хавсралт 11. Сургагч багшийн орлон заах хуваарь

M-CY-4-CYA-05-03

СУРГАГЧ БАГШИЙН ОРЛОН ЗААХ ХУВААРЬ

№	Хичээлийн үндсэн багш	Хичээлийн нэр	1-р орлон заах багшийн нэр	2-р орлон заах багшийн нэр

Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны алба				
Баримт бичгийн дугаар: Ж - СУ - 2 - 01 - 03		Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх журам		
Хувилбар №03	Мөрдөж эхэлсэн огноо: 2017.04.01	Өөрчлөлт 3	Өөрчлөлт оруулж, шинэчилсэн огноо: 2022.10.11	Хуудас 23 / 23